



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №11

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 10 дугаар сарын 01 нээс 10 дугаар сарын 30 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Өвчний сэжигтэй эсвэл үхсэн шувууд таарсан тохиолдолд: **ЗӨСҮТ-н 70282853** дугаарт эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcg.is/KXDjy>

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 10 дугаар сарын 01 нээс 10 дугаар сарын 30 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн 2 тохиолдол бүртгэгдсэн.

Камбоджи улсын Кампонгси мужид 10 сарын 17 нд 3 настай охин өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 хэвшинжээр өвдсөн. Тархвар судлалын холбогдлоор хүүхдэд шинж тэмдэг илрэхээс өмнө хүүхдийн гэрийн ойролцоо тэжээвэр шувууд өвчилж, үхсэн тохиолдлууд бүртгэгдсэн.

Мексик улсын нийслэлд 10 сарын 15 нд 20 настай эмэгтэй шувууны томуугийн H5 хэвшинжээр өвдсөн ба тухайн улсад бүртгэгдсэн 2024 оноос хойших 3 дахь тохиолдол болж байна. Өвчтөний гэрийн ойролцоогоос цуглуулсан тагтаа, нохой, шувууны аж ахуйн шувуудын сорьцоос томуугийн эерэг тохиолдлууд бүртгэгдсэн.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2025 оны 10 дугаар сарын 01 нээс 10 дугаар сарын 30 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Канад, Аргентин, Вьетнам, Өмнөд Солонгос, Польш, Испани, Португал, Унгар, Норвеги, Өмнөд Африк, Их Британи, Дани, Герман, Итали, Унгар, Ирак зэрэг 26 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 228 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Америк тивийн улс оронд шувууны аж ахуйд, Европ тивийн улс оронд нүүдлийн шувууд, Зүүн Азийн улс оронд хүний болон өрхийн тэжээвэр шувуудын дунд өвчлөл бүртгэгдсэн.


Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй	22
H5	Аргентин	Шувууны аж ахуй	1
H5N1	Австри	Гунгар хун, бор галуу	8
H5N1	Белги	Шувууны аж ахуй, тогоруу, шилийн	9

		сар, зээрд нугас, галуу	
H5N1, H5	Болгар	Шувууны аж ахуй	3
H5N1	Камбоджи	Шувууны аж ахуй, хүний өвчлөл	3
H5N1	Канад	Шувууны аж ахуй	9
H5N1	Чех	Бор галуу	2
H5N1	Польш	Шувууны аж ахуй, хун	5
H5N1	Дани	Шувууны аж ахуй, тогоруу, шилийн сар, зээрд нугас, галуу	14
H5N1	Франц	Шувууны аж ахуй, тогоруу, зээрд нугас, галуу	16
H5N1	Герман	Тогоруу, шувууны аж ахуй	53
H5N1	Унгар	Ногоохон нугас	1
H5N1	Ирак	Шувууны аж ахуй	2
H5N1	Ирланд	Бор галуу	1
H5N1	Израли	Хотон	1
H5N1	Итали	Нугас, галуу, шувууны аж ахуй	12
H5N1	Япон	Харцага, шувууны аж ахуй	2
H5N1	Норвеги	Ногоохон нугас	1
H5N1	Польш	Шувууны аж ахуй	14
H5N1	Португал	Португал	1
H5N1	Словак	Шувууны аж ахуй	5
H5N1	Өмнөд Африк	Шувууны аж ахуй, цахлай	2
H5N1	Испани	Шувууны аж ахуй, начин шонхор, халбаган хошуут	9
H5N1	Швед	Шувууны аж ахуй	2
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, галуу	7
H5N1	Недерланд	Шувууны аж ахуй	4
H5N1	Вьетнам	Шувууны аж ахуй	6

Зураг 1. 2025 оны 10 дугаар сарын 01 нээс 10 дугаар сарын 30 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



Нүүдлийн шувуудаа хайрлаж
Тэжээвэр шувуудаа хашиж

Хамгаалъя!!!